

ЯПОНЫ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Б.Сэржав *

Товч утга

Япон улсад дайны дараах эдийн засгийн сэргэлт, 60-70-аад оны жигд өндөр хөгжил болон түүнээс хойших эдийн засгийн удаан хугацааны тогтвортой өсөлтийн явцад жижиг дунд үйлдвэр улс орны эдийн засгийн бүхий л салбарт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Өнгөрсөн зууны 80-аад он гэхэд жижиг дунд үйлдвэр нь том үйлдвэрүүдтэй бие биеэ нөхөн орших хэмжээнд хүрч, хөдөлмөрийн хуваарийн энэ тогтолцоо нь Японы шитаүкэ систем хэмээн олон улсын хэмжээнд анхаарал татаж, улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг өсгөсөн гол хүчин зүйл гэгдэж байв. Жижиг дунд үйлдвэрийг хамарсан шитаүкэ тогтолцооны хөгжлийн үр дүнд Японд түүхий эд материал боловсруулахаас эхлээд тоног төхөөрөмж, эд анги, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, угсрах бүх процесс, өөрөөр хэлбэл дотооддоо бэлэн бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэлийн стил бий болсон юм.

2010 оны байдлаар Японд нийт үйлдвэрийн газрын 99%-ийг жижиг дунд үйлдвэр эзэлж, нийт ажиллагсдын 78% нь тэнд ажиллаж, аж үйлдвэрийн салбарт гэхэд л нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний талаас илүү хувийг жижиг дунд үйлдвэрт үйлдвэрлэж байна. Японы эдийн засагт сүүлийн үед бүтцийн өөрчлөлт явагдаж, үйлдвэрүүд нь далайн чанадад олноор гарах үйл явц үргэлжлэн, аж үйлдвэрийн өмнөх стил өөрчлөгдөж байгаа хэдий ч эдийн засаг, нийгмийн ирээдүйн хөгжилд жижиг дунд үйлдвэрийн гүйцэтгэх үүргийг улам бүр чухалчлан үзэх болж буй талаар тус өгүүлэлд авч үзлээ.

Түлхүүр үг: Японы жижиг дунд үйлдвэр, давхар бүтэц, шитаүкэ тогтолцоо, жижиг дунд үйлдвэрийн суурь хууль, хөөсөн эдийн засаг, бүтцийн өөрчлөлт

*Б.Сэржав – Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Японы жижиг дунд үйлдвэрийн хөгжил, цаашдын хандлага

Япон улсын Жижиг дунд үйлдвэрийн суурь хууль /中小企業基本法/-д “Аж үйлдвэрийн салбарт 300 сая хүртэл иэний үндсэн хөрөнгө, 300 хүртэл байнгын ажиллагсад бүхий үйлдвэр компанийг, Бөөний худалдааны салбарт 100 сая хүртэл иэний үндсэн хөрөнгө, 100 хүртэл ажиллагсад бүхий компанийг, Жижиглэн худалдааны салбарт 50 сая хүртэл иэний үндсэн хөрөнгө, 50 хүртэл ажиллагсад бүхий компанийг, Үйлчилгээний салбарт 50 сая хүртэл иэний үндсэн хөрөнгө, 100 хүртэл ажиллагсад бүхий компанийг жижиг дунд үйлдвэрт хамруулах”¹ -аар заажээ. 2010 оны байдлаар Японд нийт үйлдвэрийн газрын 99% -ийг жижиг дунд үйлдвэр эзэлж, нийт ажиллагсдын 78% нь тэнд ажиллаж байна². Одоогоор нийт үйлдвэрийн тоонд жижиг дунд үйлдвэрийн эзлэх хувиар Япон улс Америк, Европын холбоотой ойролцоо байгаа. Харин жижиг дунд үйлдвэрт ажиллагсдын тоогоор Япон хамгийн өндөр хувийг эзэлж байна. Эдгээр үзүүлэлт нь тус улсын эдийн засаг, нийгэм, ард түмний аж амьдралд жижиг дунд үйлдвэр үлэмж нөлөөтэй байдгийг харуулж байна. Жижиг дунд үйлдвэр нь Японд орчин үеийн аж үйлдвэржилтийн үйл явц өрнөсөн түүхийн явцад тодорхой байр суурь эзэлж, тодорхой үүргийг гүйцэтгэсээр иржээ. Тухайлбал, Мэйжийн шинэчлэлийн үеэс буюу XIX, XX зууны зааг үеэс Америк, Европын хөгжингүй орнуудын технологи, менежментийг шууд болон дам шугамаар нэвтрүүлж үйлдвэржилтийн гарааг эхлэхэд Японы уламжлалт амьдралын хэвшлээс үүсэлтэй, гэр бүлээр цөм болгосон жижиг бичил хэмжээний үйлдвэрүүд нэгэн чухал жигүүр нь болж хөгжиж чаджээ. Эдгээр үйлдвэрүүдэд нэхмэл, сүлжмэл, утас зэрэг гэх зэрэг сүлжмэлийн чиглэлийн үйлдвэрүүд, нэрмэл архи, цай зэрэг хүнсний чиглэлийн үйлдвэрүүд, шавар урлал, шаазан эдлэл, цэцгийн сав ваарын төрлийн үйлдвэрүүд голлож байжээ. Эдгээр уламжлалт үйлдвэрүүд нь шинэчлэлт, аж үйлдвэржилтийн явцад үйл ажиллагаа нь саарч, устаж үгүй болсонгүй, харин ч цаг үеийн өөрчлөлтөд идэвхтэй зохицон шинэ хэлбэрээр хөгжиж иржээ. Тухайн үед уламжлалт үйлдвэрүүд төвлөрсөн бүс нутгийн ижил төрлийн үйлдвэрүүдийн нэгдэл, хамтлаг, мэдээлэл цуглуулах, хүргэх болон зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг бөөний худалдаачид, технологийн болон менежментийн талаар уламжлалт үйлдвэрийг дэмжин туслах үүрэгтэй улсаас байгуулсан шинжилгээ туршилтын газар зэрэг олон субъектийн гүйцэтгэж байсан үүргийн талаар японы судлаачид хөндөн бичжээ³. Мөн тухайн бүс нутгийн төрөл бүрийн сургуулиуд ч хүний нөөцийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

Харин Япон улсын 1930-аад оноос олон улсын тавцанд

явуулсан гадаад улс төрийн бодлого, дайны үеийн эдийн засгийн нөхцөл байдлын улмаас жижиг дунд үйлдвэрүүд армийн хэрэгцээний зориулалтаар дайчлагдах, хүчээр нэгтгэгдэх, үйл ажиллагаа нь хязгаарлагдах, чөлөөтэй ажиллах нөхцөл нь хаагдах зэрэг бэрхшээл тохиолдож байв. Гэвч цэрэг армийн хэрэгцээнд бүрэн хэмжээгээр дайчлагдсан том үйлдвэртэй харьцуулахад жижиг дунд үйлдвэр нь дайны дараа ард иргэдийн хэрэгцээ рүү чиглэсэн үйлдвэрлэлд шуурхай шилжих боломжоор давуу байснаараа улс орны эдийн засгийн сэргэлт болон ард түмний аж амьдрал, нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж чаджээ. Дайны дараа ийнхүү жижиг дунд үйлдвэрийн үүрэг улам нэмэгдэж ирсэн хэдий ч түүхий эд материал, хөрөнгийн гүнзгий хомсдолтой тулгарч, ийм нөхцөл байдлын дунд 1947 оны 5 дугаар сард Бүх Японы ЖДҮ-ийн Зөвлөл, 1948 оны 3 дугаар сард Японы ЖДҮ-ийн холбоо гэсэн улсын хэмжээний байгууллагууд үүсэн байгуулагджээ. Энэ нь ЖДҮ-ийн дуу хоолой хүчтэй болоход нөлөөлж, улмаар ЖДҮ-ийг дэмжих төрийн бодлого идэвхжиж, 1948 онд Худалдаа, аж үйлдвэрийн яамны ЖДҮ-ийн газрыг байгуулжээ.

ЖДҮ-ийн хөрөнгө санхүүжилтийг дэмжих талаар засгийн газраас удаа дараа арга хэмжээ авч явуулсан байна. Энэ хүрээнд 1949 онд Иргэдийг санхүүжүүлэх төрийн сан /国民金融公庫/, 1953 онд ЖДҮ-ийг санхүүжүүлэх төрийн сан /中小企業金融公庫/ байгуулжээ. Бас 1950 онд ЖДҮ-ийн итгэмжлэлийн даатгалын хууль /中小企業信用保険法/, 1953 онд Итгэмжлэлийн баталгаа гаргах нийгэмлэгийн хууль /信用保証教会法/ тус тус гарч хэрэгжжээ.

Японы эдийн засаг 1950-иад оны дунд үеэс өндөр хөгжлийн шатанд шилжсэн. 70-аад он хүртэл үргэлжилсэн жигд өндөр хөгжлийн энэ үе тус орны эдийн засаг, нийгмийг эрс өөрчилж, ЖДҮ ч ихээхэн өөрчлөгдсөн юм. Өндөр хөгжлийн жилүүдийн эхний үед эдийн засагт ЖДҮ-ийн эзлэх байр суурь “давхар бүтэц” /二重構造/ гэдэг нэр томъёогоор илэрхийлэгдэж байв. Энэ нь “эдийн засагт газар тариалан болон жижиг бичил аж ахуйн эзлэх хувь өндөр, нэг талаас орчин үеийн том үйлдвэр, нөгөө талаас дээр үеийн хөдөлмөрийн харилцааг хэвээр авч үлдсэн жижиг үйлдвэр, гэр бүлийн аж ахуйд тулгуурласан бичил үйлдвэр, газар тариалан гэсэн хоёр туйлд хуваагдаж, дундаж давхрага байхгүй. Жижиг бичил үйлдвэр нь хөдөлмөрийн бүтээмж доогуур, том үйлдвэртэй харьцуулахад цалингийн болон хөдөлмөрийн нөхцлийн ялгаа ихтэй, технологийн шинэчлэл явуулахад үр ашиг муутай” гэсэн агуулгыг багтаасан нэр томъёо байв. ЖДҮ-ийг хамаарах энэхүү “давхар

бүтэц” нь эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болж, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, ДНБ-ний хэмжээ өсөх, технологийн шинэчлэл өргөн хүрээнд нэвтрэх үйл явцыг саатуулах гол нөхцөл болж байна, тиймээс “давхар бүтэц”-ийг арилгахгүйгээр Японы эдийн засаг хөгжихгүй гэх дүгнэлт⁴ ч гарч байв.

“Давхар бүтэц” эдийн засгийн ноцтой асуудал болон тавигдаж байсан 1963 онд Япон улсын Жижиг дунд үйлдвэрийн суурь хууль батлагджээ. Энэ хууль “Эдийн засаг, нийгмийн хязгаарлагдмал байдлаас үүссэн ЖДҮ-ийн ашиггүй байдлыг засан сайжруулах, ЖДҮ эрхлэгчдийн бие даасан хүчин чармайлтыг дэмжих, хөдөлмөрийн бүтээмж болон худалдааны нөхцлийг дээшлүүлэх” бодлогын зорилт хэрэгжүүлсний үндсэн дээр “давхар бүтцийг өөрчилж, аж үйлдвэрийн бүтцийг сайжруулах боломжийг бүрдүүлэхүйц хэмжээний ЖДҮ-ийг өсгөж хөгжүүлэх” зорилт дэвшүүлсэн юм. Уг хуулинд ЖДҮ-ийн бүтцийг дээшлүүлэх, ЖДҮ-ийн шинэчлэл хийх чиглэл тусгасны дагуу үйлдвэрийн газрыг хэмжээний хувьд зохистой түвшинд хүргэх, үйлдвэрүүдийг нэгтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, зохион байгуулалтын өөрчлөлт хийхийн зэрэгцээ хэт жижиг хэт олон үйлдвэрийн зохистой бус өрсөлдөөнийг таслан зогсоох, худалдааг журамлахаар заажээ. Ингэж 1963 онд батлагдсан ЖДҮ-ийн суурь хуулиар ЖДҮ-ийн бодлогыг нэгдсэн тогтолцоонд оруулж, энэ салбарт хэрэгжих хожмын хууль журмууд тус хуулинд тулгуурлах болжээ. Дээрх суурь хуулинд тулгуурлан хэрэгжүүлсэн бодлогын онцлогийн талаар судлаач Күросэ Наохиро дүгнэхдээ “1. Аж үйлдвэрийн бүтцийн бодлогын шинж бүхий ЖДҮ-ийн бодлого хэрэгжсэн, 2. Практикт хэрэгжих тал дээр хамгаалах бодлогыг түлхүү тусгасан, 3. Hard талыг чухалчилж, soft талыг орхигдуулсан, бодит байдлаас хөндий, улс даяар нэг хэв шинжид хамааруулах байдлаар авч үзсэн, бус нутгийн онцлогийг тусгаагүй”⁵ гэжээ.

1970-аад он хүртэл үргэлжилсэн эдийн засгийн жигд өндөр хөгжлийн үр дүнд Японы эдийн засаг хөгжингүй орнуудын дунд баттай байр суурь эзэлж, Америкийн дараа дэлхийд хоёрдугаарт орох том эдийн засаг болсон. Өмнө өгүүлсэнчлэн Японы ЖДҮ эдийн засгийн жигд өндөр хөгжлийн эхний үед “давхар бүтэц”-ийн дотор доод давхаргыг нь эзэлж, ашиг муутай, хөдөлмөрийн бүтээмж багатай, хөдөлмөрийн нөхцөл хүнд хэмээн тооцогдож байсан бол ЖДҮ-ийг дэмжих төрийн идэвхтэй бодлогын үр дүн, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн явцад Японы аж үйлдвэрийн бүтцийн чухал хэсэг болж чадах хэмжээнд хүртэл шинэчлэгдэн хөгжжээ. Үүнд 1. Жигд өндөр хөгжлийн жилүүдэд шинээр сургууль төгссөн залуу

ажиллах хүчин хөдөлмөрийн зах зээлийг тэтгэсэн, мөн ЖДҮ-үүд өөрсдөө тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт идэвхтэй хийсний үр дүнд том үйлдвэр болон ЖДҮ-ийн хөдөлмөрийн нөхцлийн ялгаа мэдэгдэхүйц багасч иржээ. 2 Эдгээр үйлдвэрийн дундаас ЖДҮ-ийн хэмжээнээс давж гарсан дунд хэмжээний үйлдвэр /中規模企業/ гэгдэх шинэ маягийн үйлдвэрүүд ч төрөн гарч, хөгжиж эхэлсэн байна. 3 ЖДҮ тооны хувьд улам өсч иржээ. ЖДҮ-ийн суурь хуулинд зохистой бус өрсөлдөөн үүсгэх нөхцлийг бий болгох “хэт олон, хэт жижиг” байдлыг халах зорилт дэвшүүлж байсан хэдий ч жигд өндөр хөгжил нь ЖДҮ шинээр байгуулагдах боломжийг нээсээр, ЖДҮ-ийн тоо жилээс жилд нэмэгдэх үйл явц 80-аад оны сүүл хүртэл үргэлжилсээр байлаа.

80-аад онд Японы хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн технологи эрс дээшилж, гэр ахуйн цахилгаан бараа, компьютерийн эд анги, машин техник зэрэг бүтээгдэхүүний өрсөлдөх чадвараар дэлхийд ноёлох болж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи, цаг үеийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байв. Мөн жигд өндөр хөгжлийн эхэн үеэс хурдтай хөгжиж ирсэн автомашины үйлдвэрлэл ч 70-аад онд Тоёота загварын үйлдвэрлэлийн систем нь зардал, чанарын хувьд олон улсын хэмжээнд тэргүүлэх зэргээр японы үйлдвэрийн брэнди дэлхийн зах зээлд байр сууриа эзэлсэн юм. Японы үйлдвэрийн дээрх амжилтын чухал тулгуур нь бараа бүтээгдэхүүний эд анги үйлдвэрлэдэг ЖДҮ байсан юм. Ер нь өнгөрсөн зууны 80-аад он гэхэд ЖДҮ нь улс орны эдийн засгийн бүхий л салбарт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болж, том үйлдвэрүүдтэй харилцан бие биеэ нөхөн орших хэмжээнд хүрч, өөрийн гэсэн өвөрмөц технологитой, үйл ажиллагаа, зохион байгуулалт нь маш уян хатан, эдийн засгийн нөхцөл байдалд хурдан шуурхай зохицож чаддаг гэх зэрэг онцлог шинжийг бүрдүүлж, хөгжлийн өндөр түвшинд нэгэнт хүрээд байв.

Японы үйлдвэрлэлийн системийн давуу талын гол хүчин зүйлийг ЖДҮ-ийг хамруулсан хөдөлмөрийн хуваарийн тогтолцоо буюу Японы шитаүкэ систем гэдгийг судлаачид олонтаа тэмдэглэсэн байдаг. Шитаүкэ системийн талаар Эдийн засгийн толь бичигт тодорхойлсноор “Захиалагч үйлдвэр нь захиалга хүлээн авагч /шитаүкэ/ үйлдвэрт бүтээгдэхүүн, эд ангийн үйлдвэрлэл, боловсруулалт, засвар зэргийг шууд захиалж хийлгэх тогтолцоонд суурьлсан үйлдвэрлэлийн өвөрмөц хэлбэр. Захиалагч үйлдвэр нь менежментийн нөөцийн давуу талаа ашиглан худалдаанд монопол эрх эдлэх, шитаүкэ үйлдвэрийн үнэ тогтоох үйл ажиллагаанд

Японы жижиг дунд үйлдвэрийн хөгжил, цаашдын хандлага

нөлөөлөх зэргээр зах зээлд ноёлох байр суурьтай байдаг. Бизнесийн ийм харилцаанаас үүдэн захиалагч болон захиалга хүлээн авагч үйлдвэрийн хооронд захирах, захирагдах харилцан хамаарал тогтдог”⁶, мөн “монопол эрхтэй том үйлдвэрт ажлыг нь хөлсөөр хийдэг, ажиллах хүч нийлүүлдэг, жижиг дунд, бичил үйлдвэр нь эдийн засгийн тогтолцоонд чухал хүчин зүйл болж, том үйлдвэрт хараат байдлаар зохион байгуулагдсан байдал”⁷ гэжээ.

Японы аж үйлдвэрийн бүтцийн чухал онцлог болох шитаүкэ тогтолцооны эхлэл, мөн шитаүкэ хэмээх нэр томъёо нийтийн хүрээнд хэвшиж эхэлсэн зэрэг нь Япон улс 1930-аад оноос армийн хэрэгцээний аж үйлдвэрийн зохион байгуулалтын хүрээнд жижиг дунд үйлдвэрийг хүчээр шитаүкэ болгон дайчилж байснаас үүдэлтэй. 1941 онд шитаүкэ үйлдвэрүүдийг том үйлдвэрийн хамтын ажиллагаат үйлдвэр маягаар нэр томъёог өөрчилж байв. Гэвч дайны дараа эдийн засаг сэргэж эхлэхэд, 1948 оноос жижиг дунд үйлдвэрүүд дахин шитаүкэ байдлыг сэргээх болжээ. Энэ нь тухайн үеийн технологийн шинэчлэл, аж үйлдвэрийн төрөлжилтийн явц шитаүкэ ЖДҮ-г өсч хөгжих шинэ боломжийг олгож эхэлсэнтэй холбоотой байжээ. Түүнийг залган жигд өндөр хөгжлийн жилүүдэд систем шинээр эмхлэгдэж, ганц үйлдвэрийн захиалгыг дагнасан жижиг дунд үйлдвэрийн давхарга, түүний дээд талд захиалагч том үйлдвэр гэсэн аж үйлдвэрийн пирамид хэлбэрийн бүтэц өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн кэйрицү⁸ тогтолцоо бүрэлдэж, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, өрсөлдөөнийг идэвхжүүлэхэд түлхэц болжээ. Энэ үед ЖДҮ-үдийн хувьд нэгд, жигд өндөр хөгжлийн жилүүдэд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл эрчимтэй өргөжих явцад урьд ЖДҮ-ийн хүрээнд багтаж ирсэн шитаүкэ үйлдвэрүүд хөгжин, хэмжээний хувьд тэлж, байр суурь нь батжиж ирсэн. Ялангуяа ЖДҮ-ийн дотроос шитаүкэгийн байр сууриа хадгалсан хэвээр өргөжин хөгжсөөр ЖДҮ-ийн хэмжээнээс давж гарсан шинэ үйлдвэрүүд

⁶ Ямар нэгэн үйлдвэр корпораци хувьцаа эзэмших, мэргэжилтэн томилж ажиллуулах, хөрөнгө оруулалт, түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэх, шитаүкэ харилцаа зэргээр дамжуулан бусад үйлдвэрийг нөлөөндөө оруулах тогтолцоо. Кэйрицү үйл ажиллагааны зорилго нь өөрийн компанийн бүтээгдэхүүний нийлүүлэх түншийг баталгаатай байлгах, байр сууриа өргөжүүлэх, үйлдвэрлэлийн бусад салбарт үйл ажиллагаагаа өргөтгөх, шитаүкэ үйлдвэртэй болох зэрэгт оршино. Кэйрицү тогтолцоо нь том аж үйлдвэрээр толгойлуулсан пирамид хэлбэрийн бүтэц бүхий үйлдвэрүүдийн төвлөрөлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл хувьцааны өмчлөл, мэргэжилтэн томилгоо, санхүүжилтийн талаар нягт хамааралтай шууд охин компаниас эхлээд нэг субъектийн хувьцаа эзэмших, мэргэжилтэн илгээх хэмжээний харьцангуй хамаарал багатай кэйрицү үйлдвэр, улмаар үйлдвэрлэл, технологи, тоног төхөөрөмж, материал, худалдаа, борлуулалт, санхүү хөрөнгийн харилцаа бүхий менежментийн хамааралтай кэйрицү үйлдвэр, анхдагч, хоёрдогч шитаүкэ жижиг дунд үйлдвэр гэхчлэн том групп болж зохион байгуулагддаг.

олноор бий болсон, Хоёрт, эдийн засгийн жигд өндөр хөгжлийн явцад асар олон ЖДҮ шинээр байгуулагдаж, шинээр үүсэн байгуулагдсан тэдгээр үйлдвэрийн олонхи нь тус тусын салбарт шитаүкэ үйлдвэрийн тогтолцоонд орсоор байсан. Үүгээрээ жигд өндөр хөгжил нь ЖДҮ-ийн хувьд шитаүкэ болж том үйлдвэрээс захиалга авах боломжийг улам нэмэгдүүлж, шинээр шитаүкэ-д орох явдлыг ч улам түргэтгэсээр байсан гэх зэрэг бодит өөрчлөлт гарчээ.

Шитаүкэ үйлдвэр хэлбэрийн хувьд 1980-аад оны сүүлч гэхэд ерөнхийдөө дараах 3 чиглэл тухайлбал, 1. Цаашид тодорхой нэг том үйлдвэрийн шитаүкэ байр сууриа улам бататгаж, тухайн брэндийн бүтээгдэхүүнд дагнан оролцох чиглэлтэй үйлдвэрүүд, 2. Олон тооны захиалагч том үйлдвэртэй байж, зохион бүтээх чадавхиа дээшлүүлэн, бүтээгдэхүүнээ олон үйлдвэрт нийлүүлдэг, өөрийн дагнасан брэндийн эд анги үйлдвэрлэх, боловсруулах чиглэлийн үйлдвэрүүд, 3. Өөрийн үйлдвэрт шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхиа бэхжүүлж, зах зээлд борлуулах хүчин чадал бүхий бие даасан үйлдвэр болох зорилго бүхий үйлдвэрүүд² гэсэн чиглэлээр оршиж байв. Энэ үеийн онцлогийн талаар захиалагч том үйлдвэр болон шитаүкэ ЖДҮ-ийн хоорондын харилцааны ерөнхий хандлага урьдын босоо чиглэлийн захирах, захирагдах шинжтэй бизнесийн харилцааны удаан хугацааны хаалттай бүтцээс үйлдвэрлэлийн төрөл, салбарын хувьд харилцан адилгүй ч нээлттэй, харьцангуй тэгш эрх бүхий шитаүкэ тогтолцоо болж, нийгмийн хөдөлмөрийн хуваарьт шинэчлэлт гарчээ³.

Шитаүкэ үйлдвэрийн талаар төрөөс явуулах бодлогыг 1956 оны “Шитаүкэ үйлдвэрт хийх төлбөрийг хугацаа сунгахыг хориглох хууль” /下請代金支払遅延防止法/, 1970 оны “Шитаүкэ жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хууль” /下請中小企業振興法/-иар зохицуулан хэрэгжүүлж ирсэн бөгөөд захиалагч том үйлдвэр давуу байр сууриа хэтрүүлэн ашиглах явдлыг хязгаарлах болон монополийн эсрэг бодлогын хүрээнд шитаүкэ үйлдвэрийн бизнесийн орчин /өрсөлдөөний орчин/-ыг сайжруулах, ялангуяа шитаүкэ ЖДҮ болон том үйлдвэрийн харилцан эрх тэгш байр суурийг амьдрал дээр хэрэгжүүлэх, ЖДҮ биеэ даан хөрөнгийн хуримтлалтай болох нөхцлийг /шитаүкэ үйлдвэрийн бүтээгдэхүүний үнийг зохистойгоор тогтоох/ бүрдүүлэх зэрэг чиглэлээр бодлогын арга хэмжээ авчээ.

Өмнө өгүүлсэнчлэн 50-иад оны үед ЖДҮ тоогоор хэт олон, хэмжээгээр хэт жижиг, хоцрогдсон технологитой, хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй, цалингийн ялгаа ихтэй эдгээр нөхцөл нь улс орны

эдийн засгийн хөгжлийг хойш татаж байгаа гэх үзэл давамгайлж байсан бол харин 80-аад он гэхэд ЖДҮ-ийн талаарх дээрх үзэл бодол эрс өөрчлөгдөж, ЖДҮ-ийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тэмдэглэх болжээ. Японд 1963 оноос жил тутам нийтлэгдэж ирсэн “Жижиг дунд үйлдвэрийн Цагаан ном”-ын 1984 оны хэвлэлд “Сүүлийн үед боловсруулах, угсрах чиглэлийн аж үйлдвэр үлэмж хөгжиж ирсэн нь үйлдвэрлэлийн хуваарийн өндөр үр ашиг бүхий шитаүкэ бүтэц байгаатай холбоотой”¹⁰ гэжээ. Энд Японы үйлдвэрлэлийн шитаүкэ бүтцийн онцлогийг Өмнөд Солонгос болон Америктай харьцуулж, 1. Үйлдвэрийн гадна талд хийж буй хувь өндөр, 2. Үнийг хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоодог, 3. бүтээгдэхүүний чанарын өндөр шаардлага тавигддаг, 4. Захиалагч том үйлдвэрийн зүгээс байнгын удирдлага, дэмжлэг үзүүлдэг зэрэг нь Японы үйлдвэрийн тогтолцооны онцлог хэмээн дурджээ. Тэгвэл 1986 оны Цагаан номонд “Манай улсын шитаүкэ бүтэц нь 1. Ажил үүргийн үр ашигтай хуваарилт, 2. Мэдээллийн зардлын хэмнэлт, 3. Мэдээллийн шуурхай, саадгүй чанар зэрэг талаар маш үр ашигтай үйлдвэрлэлийн тогтолцоо болж чадсан”¹¹ гэжээ.

Японы шитаүкэ системийн онцлогийн талаар доктор Үэда Хирофүми судалгаандаа “1. Захиалагч талын хувьд үйлдвэрийн гадна тал дахь үйлдвэрлэлийн хэмжээ ихэнхи хувийг эзлэх хэдий ч холбоотой ажиллаж захиалга өгдөг гадна талын харилцагч цөөнтэй байдаг. Бүтээгдэхүүн захиалж хийлгэдэг тодорхой цөөн тооны үйлдвэртэй маш нягт холбоо тогтоосон байдгаар онцлогтой. 2. Захиалагч болон захиалга хүлээн авагч талын хамтын ажиллагаа удаан хугацаагаар үргэлжилдэг. Энэ нь анхнаас зориуд төлөвлөсөн харилцаа бус харин эдийн засгийн удаан хугацааны өсөлт болон үйлдвэрлэл тогтвортой өргөжиж байсны үр дүнд бий болсон харилцаа байдаг. 3. Захиалагч болон захиалга хүлээн авагч талын ажил хэргийн харилцаа холбоо нь удаан жилийн хамтын ажиллагааны зарчим дээр тулгуурладаг. Өөрөөр хэлбэл олон жилийн нөхөрлөлийн үндсэн дээр хоёр талын худалдаанд гарах янз бүрийн асуудлыг зохицуулж чаддаг. 4. Чанар (Quality), зардал (Cost), хүлээлгэн өгөх хугацаа (Delivery) зэрэг нь хатуу зохион байгуулалтанд байдаг. QCD-ийн удирдлага, зохион байгуулалт нь захиалагч том үйлдвэр болон шитаүкэ ЖДҮ-т адил, нэг арга барилаар хэрэгждэг. 5. Шитаүкэ-гийн энэхүү системийн үндсэн дээр мэдээлэл тасралтгүй, шуурхай дамжиж, захиалагчийн эрэлт хүсэлтэд шитаүкэ үйлдвэр шуурхай, уян хатнаар зохиож, өндөр чанартай, хямд үнэтэй бүтээгдэхүүн нийлүүлэгдэж ирсэн”¹²-ийг цохон тэмдэглэжээ. Шитаүкэ

системийн эдгээр онцлог шинж нь Японы аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг өсгөсөн гол хүчин зүйл болсон, энэ систем 1970-80-аад онд аж үйлдвэрлэл эрс хурдацтай өргөжиж, ЖДҮ-ийн тоо огцом нэмэгдэж байсан тэр үед батжин бүрэлдсэн ажээ. Ялангуяа жигд өндөр хөгжлийн жилүүдийн дараах удаан хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлт, түүний үр дүнд бий болсон үйлдвэрлэлийн тэлэлт нь энэ тогтолцоо батжин төлөвших нөхцлийг бий болгожээ. ЖДҮ-ийнхэн цаашдын удаан жилийн хамтын ажиллагааг тооцон тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж, захиалагч тал ч мөн удаан хугацааны хамтын ажиллагаагаа бодолцон шитаүкэ үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд дэмжлэг үзүүлж иржээ.

Японы шитаүкэ системийн гол төлөөлөл нь асар олон тоогоор үйлдвэрлэдэг автомашин, электроник, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн том үйлдвэрүүдэд эд анги нийлүүлдэг төрөлжсөн ЖДҮ-үүд юм. Ийм үйлдвэр нэхмэл, сүлжмэлийн болон бусад салбарт ч дийлэнх хувийг эзэлж байдаг, тооны хувьд Японы нийт ЖДҮ-ийн талаас илүү хувь нь шитаүкэ үйлдвэр байдаг ажээ. Олонхи ЖДҮ нь хөдөлмөрийн нөхцлөөр том үйлдвэрийн газрын хэмжээнд хүрдэггүй, ялангуяа энд ажиллагсад том үйлдвэрт ажиллагсдаас удаан цагаар ажиллаж, доогуур цалин хөлс авдаг, боловсон хүчний хувьд ч их сургуулийг сайн үнэлгээтэй төгсөгчид болон нэртэй их сургууль төгсөгчид мөн л нэртэй том үйлдвэр компанид ажилд ордог ЖДҮ-т сайн боловсон хүчин төдий л олддоггүй гэх зэрэг бараан ойлголтууд байдаг. Гэвч ЖДҮ-үүд нь захиалагчаас ирсэн захиалгыг хүлээн авч, түүний дагуу үйлдвэрлэл явуулах төдий үйл ажиллагаатай байдаггүй. Олон ЖДҮ захиалагч үйлдвэрт хандсан бүтээлч санаачилга гаргаж, үүгээрээ том үйлдвэрийн үйлдвэрлэл эхэлснээс хойших үйл ажиллагаа, түүнчлэн үйлдвэрлэл эхлэхээс өмнөх зураг төслийн шатны үйл ажиллагаанд ч нөлөө үзүүлж чаддаг ажээ. Том үйлдвэрийн зураг төсөл, үйлдвэрлэлийн шатан дахь алдаа дутагдлыг шитаүкэ үйлдвэрт илрүүлж, залруулах аргын талаар захиалагчид санал оруулдаг, үүгээрээ тухайн брэндийн бүтээгдэхүүний чанарын болон бусад үзүүлэлт улам сайжрахад хувь нэмэр оруулдаг байна. Ийнхүү шитаүкэ үйлдвэрүүд хамтын ажиллагааны явцад идэвхтэй санал гаргаж, захиалагч тал түүнийг хянан хэлэлцэж, хүлээн авдаг бүтэц нь Японы шитаүкэ системийн нэг онцлог юм.

Шитаүкэ тогтолцооны хөгжлийн үр дүнд 1990-ээд он гэхэд Японд түүхий эд материал боловсруулахаас эхлээд тоног төхөөрөмж, эд анги, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, угсрах бүх процесс бүгд дотооддоо хийгддэг байсан, өөрөөр хэлбэл дотооддоо бэлэн

бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэлийн стил бий болсон байв.¹³

Харин 90-ээд оноос хойш, ялангуяа хөөсөн эдийн засгийн уналтаас хойш Японы аж үйлдвэрийн ийм нөхцөл эрс өөрчлөгдөхөд хүрсэн юм. Тухайлбал, хөөсөн эдийн засгийн уналтын дараа аж үйлдвэрийн олон салбарт үйлдвэрлэлийн түвшин өмнөх оргил үеийн хэмжээнд буцаж орж чадаагүй юм. Гадаадад шилжсэн үйлдвэрүүдийн тухайн улс дахь үйлдвэрлэл өргөжиж байсан боловч дотоодын эрэлт хэрэгцээний өсөлтийн зогсонги байдал үргэлжилж байв. Мөн бэлэн бүтээгдэхүүнийг дотооддоо бүрэн үйлдвэрлэдэг байсан загвар өөрчлөгдөж, гадаадад гарсан үйлдвэрүүдэд эд анги, материал нийлүүлэх чиглэл бий болов. Өөрөөр хэлбэл хөөсөн эдийн засгийн уналтын дараа эдийн засаг суларсан, глобал өрсөлдөөн бий болсон, үйлдвэрүүд олноор гадаадад шилжсэн зэргээс болж үйлдвэрлэлийн хуучин хэв маягийг хадгалах боломж алдагджээ. Мөн Хятадын эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр үйлдвэрлэлийн зардлын өрсөлдөөн ихэссэн зэрэг олон хүчин зүйл Японы жижиг дунд үйлдвэрт нөлөөлөх болжээ. Том үйлдвэрүүд зардал хямдтай гадаадын үйлдвэрүүдэд захиалга өгөх чиглэл барих болж, шитаүкэ үйлдвэрээ өөрчлөх хандлага нэмэгдсэн байна. 1989 оны “Жижиг дунд үйлдвэрийн Цагаан ном”-д “Үйлдвэрлэлийн хуваарилтын шитаүкэ бүтэц худалдааны улам нээлттэй харилцаа руу шилжиж байна. Том үйлдвэр болон шитаүкэ үйлдвэрийн хоорондын холбоо сулрах хандлагатай болж байна”¹⁴ мөн уламжлалыг үл харгалзан шилдэг технологитой шитаүкэ үйлдвэрийг сонгох, зардлыг чухалчлан, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгчийн тоонд гадаадын үйлдвэрүүдийг оролцуулах гэх зэрэг хэлбэрээр том үйлдвэрүүд шитаүкэг сонгох боллоо”¹⁵ гэжээ.

Бизнесийн харилцааны ийм өөрчлөлт нь ЖДҮ-ийн өмнө цөөн бус шинэ асуудлыг гаргаж иржээ. Тухайлбал, 1. Японы үйлдвэрүүд эд анги нийлүүлэх стратегиэ шинэчилснээс дотоодын хуучин бизнесийн харилцаа баталгаатай байх нь тодорхой бус болсон.

2. Үнийн өрсөлдөөн глобал хэмжээнд өрнөх болж, үйлдвэрлэлийн зардлын өрсөлдөөн ширүүссэн. Энэ нь ЖДҮ-ийн хувьд урьд өмнө байгаагүй хэмжээгээр зардлаа бууруулах шаардлага тулгасан гэсэн үг. Ялангуяа Хятад мэтийн далайн чанадаас нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүн, эд анги маш хямд зардалтай байсан нь Японы ЖДҮ-үүдэд өрсөлдөөнд тэсч гарахад хүнд нөхцлийг үүсгэсэн.

3. Гадаад дахь үйлдвэрээ оролцуулсан глобал нийлүүлэлт, урьдын дотоодын үйлдвэрүүд хоорондын харилцааг халсан нээлттэй

худалдаа нь нэг талаар ЖДҮ-ийн хувьд худалдааны шинэ боломжийг бий болгожээ.

Ийнхүү 90-ээд оноос Японы эдийн засагт явагдсан бүтцийн өөрчлөлтийн явцад том болон шитаүкэ үйлдвэрүүдийн хооронд удаан хугацаагаар тогтож ирсэн харилцаа өөрчлөгдөж, ЖДҮ-үүд шитаүкэ хамаарлаас гарахыг эрмэлзэх үзэгдэл ч гарч иржээ. Мөн Азийн бүс нутагт үйлдвэрлэл сэргэж эхэлсэн, Японы иэний ханш огцом чангарсан зэрэг гадаад дотоод нөхцөл байдал нь ЖДҮ-ийн орчинд эрс өөрчлөлт гаргасан юм. 1996 оны ЖДҮ-ийн Цагаан ном-д "Цаашид технологийн чадавхиа улам дээшлүүлж, зардлыг хямдруулах, шинэ шинэ бүтээгдэхүүн бий болгох шаардлага тулгарч байна. Мөн Азийн бүс нутагт үйлдвэрлэл явуулах, технологи шилжүүлэх зэрэг олон улсын хэмжээний стратеги боловсруулж ажиллах шаардлага тулгарч байна"¹⁶ гэжээ.

Энэ үеэс Японы үйлдвэрүүд хямд ажиллах хүчтэй том зах зээлийг зорьж, голдуу Хятад, Америк болон Азийн орнуудад үйлдвэрлэлээ шилжүүлж эхэлсэн юм. 2008 оны байдлаар Японы 17658 үйлдвэр далайн чанадад үйл ажиллагаа явуулж байв. Үүнээс 13417 нь том аж үйлдвэр, 4241 нь ЖДҮ байв¹⁷. Гадаад дахь үйлдвэрүүдийн талаас илүү хувь /54,9%/ нь Хятад улсад, түүнээс гадна Америк /10,9%/, Тайланд /9,6%/, Гонконг /4,6%/, Индонез /4,6%/ зэрэг оронд ажиллаж, цаашид Вьетнам, Энэтхэгт олноор гарах хандлагатай байжээ. Тэдгээр үйлдвэрүүд үйлдвэрлэлийн зардлаа бууруулах, тухайн оронд шинэ зах зээл нээж борлуулалтыг өсгөх, улмаар Японы болон гурав дахь зах зээлд экспортлох зорилготой байв¹⁸. Гадаадад үйл ажиллагаа явуулж буй эдгээр ЖДҮ болон Японы дотоодод үйлдвэрлэл явуулж буй ЖДҮ-ийн хөдөлмөрийн хуваарийн тухайд Японы зах зээлд зориулсан, өндөр технологи шаардсан, нэмүү өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл голдуу дотооддоо ажиллаж буй ЖДҮ-г ногдож байна. Гадаадад ажиллаж буй компаниудын хувьд эхний үед "шилдэг боловсон хүчин олж авч ажиллуулах, боловсон хүчин бэлтгэх, цалин хөдөлмөрийн хөлс нэмэх, цаашилбал валютийн ханшны хөдөлгөөн, бүтээгдэхүүний худалдан авагч олж авах, чанарын хяналт, тухайн орон нутгийн тогтолцооны өөрчлөлттэй зохицох" гэх зэрэг гол төлөв менежментийн холбогдолтой асуудал тулгардаг байна¹⁹.

Японд хөөсөн эдийн засаг унаж 10 гаруй жил үргэлжилсэн эдийн засгийн зогсонги байдал, Азийн санхүүгийн хямрал, 2008 оны дэлхийн эдийн засаг санхүүгийн хямрал зэрэг нь эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж, дотоодын эрэлт хэрэгцээ буурч, хямд

Японы жижиг дунд үйлдвэрийн хөгжил, цаашдын хандлага

үнэтэй импортын бараа зах зээлд ихээр нэвтэрснээр юмны үнэ унаж, эдийн засагт дефляци бий болсон. Түүний дээр эдийн засагт бүтцийн өөрчлөлт түргэсч, үйлдвэрийн газар шинээр байгуулагдах болон хаагдах үзэгдэл тооны хувьд урьдынхаас эрс нэмэгдлээ. Шинээр байгуулагдах үйлдвэрийн тооноос хаагдах үйлдвэрийн тоо илүү гарч, 90-ээд оноос хойш үйлдвэрийн газрын тоо цөөрөх хандлага үргэлжилж байна. Тухайлбал, жижиглэн худалдаалах салбарт 1981-86 он, аж үйлдвэрийн салбарт 1989-91 он, бөөний худалдааны салбарт 1994-96 оноос үйлдвэрийн газрын тоо цөөрөх хандлага бий болсон нь өнөөг хүртэл үргэлжилж байна. Хэдий тийм боловч 2010 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын ЖДҮ л гэхэд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний талаас илүү хувийг үйлдвэрлэж, тус салбарын гол хөдөлгөгч хүчний үүргийг гүйцэтгэсэн хэвээр байна. Мөн ЖДҮ нь худалдаа, борлуулалтын хэмжээгээрээ бөөний болон жижиглэн худалдааны 60 гаруй хувийг эзэлж²⁰ бараа гүйлгээний салбарт чухал үүрэг гүйцэтгэж байна. Харин үйлчилгээний салбарт шинээр нээгдэх үйлдвэрийн тоо тогтмол өсөлттэй байгаа юм. Шинээр үйлдвэр байгуулагдах явдал нь хуучин ЖДҮ-ийн менежментийн шинэчлэлтэй зэрэгцэн эдийн засгийн идэвхжилд чухал үүрэг гүйцэтгэдэг гол хүчин зүйл юм. Үйлдвэр үүсгэн байгуулагчдын хүчин чармайлтыг дэмжих тухайлбал “ЖДҮ шинээр байгуулахыг хөхүүлэн дэмжих үүднээс төрөөс үйлдвэр байгуулахтай холбогдуулан мэдээллээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг улам боловсронгуй болгох, санхүүжилтийг шуурхай болгох талаар бодлогын арга хэмжээ авахын зэрэгцээ үйлдвэрийн газар байгуулагдахын ач холбогдол, шаардлагын талаарх нийт иргэдийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэхэд тус дөхөм үзүүлэх”²¹ тухай заалтыг 1999 онд шинэчлэгдсэн Жижиг дунд үйлдвэрийн шинэ суурь хуулинд тусгажээ.

ЖДҮ-ийн цаашдын нөхцөл байдалд зайлшгүй нөлөөлөх бас нэг хүчин зүйл нь Японы нийгмийн тулгамдсан асуудал болоод буй хүүхдийн тоо цөөрөх, нийгэм насжих үйл явц юм. Японы Нийгмийн хамгаалал, хүн амын асуудал судлах институтийн судалгаагаар Япон улсын нийт хүн амын тоо 2005 онд анх удаа өмнөх оныхоос буурсан үзүүлэлт гарчээ. Уг судалгаанаас үзэхэд 2035 он гэхэд нийт хүн ам 2008 оны хүн амын 87% буюу 110 сая 670 мянга болж цөөрөх тооцоо гарчээ²². Мөн 15-64 насны буюу хөдөлмөрийн насны хүн амын тоо буурах хандлага 1996 оноос бий болсон бөгөөд эдгээр бодит байдал нь ЖДҮ-ийн өмнө боловсон хүчний асуудал, үйлдвэрийн хойчийг залгамжлах асуудал, технологи, ур чадварын

түвшингээ цаашид хадгалж авч явах асуудал зэрэг бэрхшээлийг бий болгосоор байна.

Японы эдийн засаг, нийгмийн ирээдүйн хөгжилд жижиг дунд үйлдвэрийн гүйцэтгэх үүргийг сүүлийн үед улам чухалчлан авч үзэх боллоо. Японд ХХ зууныг том бизнесийн цаг үе гэж хэлж болох бол ХІХ зууныг жижиг дунд үйлдвэрийн зуун гэж хэлж болно гэх хандлага ч гарч, жижиг дунд үйлдвэрийн цаашдын хөгжилд ихээхэн найдлага тавьж байгааг ихэнх судлаачид дорх хэдэн хүчин зүйлтэй холбон үзэж байна. - Эдийн засгийн олон салбарт оршиж буй ЖДҮ менежментийн чадавхиа ашиглан шинэ салбарт гарч, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ бий болгох чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа бөгөөд үүгээрээ Японы эдийн засаг, нийгмийн улам төгөлдөршсөн шатанд аж үйлдвэр хөгжих эх сурвалж нь болж өгөх бололцоотой. Ялангуяа цомхон бүтэц зохион байгуулалтаараа том үйлдвэрээс ялгарах ЖДҮ-ийн хувьд нөхцөл байдлын өөрчлөлтөд уян хатнаар зохицох чадвар, өөрөөр хэлбэл үйл ажиллагааны хурд шаардах цаг үед зохицон ажиллах чадвар нь дээрх боломжийг бий болгоно.

Японы хэрэглэгчид, ард иргэдийн хэрэгцээ олон талтай, өөрчлөлт ихтэй байдаг, энэ нь тал бүрийн бүтээлч сэтгэлгээ хөгжүүлсэн ЖДҮ-ийн хувьд оршин тогтнох боломжийг шинээр нээж байдаг. Сүүлийн үед амьдралын өндөр чанар, аюулгүй байдал, орчны эрүүл ахуйн шаардлага улам бүр дээшилж байгаа энэ нөхцөлд ЖДҮ-ийн гүйцэтгэж чадах үүрэг улам нэмэгдсээр байна.

- Ажлын байрыг шинээр бий болгож байдгийн хувьд ЖДҮ-ийн гүйцэтгэх үүрэг үлэмж их. Түүнчилэн ЖДҮ нь ард түмний аж амьдралд хамгийн ойр байдгаараа ажил хөдөлмөрийн олон хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах боломжийг оршин суугчдад олгож чаддаг. Эмэгтэйчүүд, өндөр настнуудад ажлын байрны боломж олгох талаар ЖДҮ тухайн бүс нутаг, нийгэмдээ чухал үүргийг гүйцэтгэж чаддаг.

- Японы ЖДҮ тооны хувьд олноос гадна газар зүйн байрлалаар тодорхой бүс нутагт төвлөрч, харилцан нягт холбоотой сүлжээ, хөдөлмөрийн хуваарийг тогтоож ирсэн нь үйлдвэрлэлийн үр ашгийг нь улам дээшлүүлж өгдөг.

- Японы том үйлдвэр болон ЖДҮ-ийн хоорондын харилцаа нь шитаүкэ систем хэмээн нэрлэгдэж, тус улсын аж үйлдвэрийн хүчирхэг байх нэг нөхцөл хэмээн тооцогдож ирсэн бөгөөд Японы том болон ЖДҮ-ийн хамтын ажиллагаа нь цаг үеийн өөрчлөлтийн явцад улам олон талтай болсоор байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ:

- 1 中小企業基本法、第1章、第2条、1999
- 2 商工総合研究所編 「日本の中小企業、図説」2010、x.
- 3 植田浩史、桑原武志、本多哲夫、義永忠一「中小企業 ベンチャー企業論」有斐閣 コンパクト、2011、北島滋、山本篤民「中小企業研究入門」文化書房博文社、2010、黒瀬直宏「中小企業政策」日本経済評論社、2006 г.м.
- 4 植田浩史、桑原武志、本多哲夫、義永忠一「中小企業 ベンチャー企業論」有斐閣 コンパクト、2011、x. 29
- 5 直宏黒瀬「中小企業政策の総括と提言」同友館、1997、x. 135-141
- 6 「経済学辞典、第3版」岩波書店、1992、x. 587
- 7 「有斐閣経済辞典」第4版、2002年
- 8 「経済学辞典、第3版」岩波書店、1992、x. 588
- 9 МОН ТЭНД
- 10 「中小企業白書、1984年版」第2部、第6章、x. 389
- 11 中小企業白書、1984年版、x. 64
- 12 植田/浩文、桑原武志、本多哲夫、義永忠一著「中小企業 ベンチャー企業論」有斐閣 コンパクト、2011、x. 109-110
- 13 植田浩文、桑原武志、本多哲夫、義永忠一著「中小企業 ンチャー企業論」有斐閣コンパクト、2011、x. 115
- 14 中小企業白書、1989年版、x. 106
- 15 中小企業白書、1989年版、x. 108
- 16 中小企業白書、1996年版、x. 203
- 17 商工総合研究所 編「日本の中小企業 2010、図説」2011、x. 42-43
- 18 МОН ТЭНД
- 19 商工総合研究所 編「日本の中小企業 2010、図説」2011、x. 47
- 20 МОН ТЭНД, x. 10
- 21 中小企業基本法、第2章、第1節、第13条
- 22 中小企業白書、2010年版、x. 131

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. 中小企業基本法、1968年、1999年
2. 岩波書店「経済学辞典」第3版、1992年
3. 有斐閣「経済辞典」第4版、2002年
4. 黒瀬直宏「中小企業政策」日本経済評論社、2006
5. 植田浩史、桑原武志、本多哲夫、義永忠一「中小企業 へ

ンチャー企業論」有斐閣コンパクト、2011

6. 北島滋、山本篤民「中小企業研究入門」文化書房博文社、2010
7. 商工総合研究所 編「日本の中小企業 2010、図説」2011
8. 直宏黒瀬「中小企業政策の総括と提言」同友館、1997
9. 中小企業庁 編「中小企業白書」1984年版、1989年版、1991年版、1996年版、2010年版
10. 経済企画庁 編 「経済白書 平成4年版」
11. 中村秀一郎 著「21世紀型中小企業」岩波新書、1992
12. Т. Намжим “Япон орон тоймлон харвал” УБ., 1999
13. “Япон хэл, соёл” эмхэтгэл, УБ., 2008
14. “Зүүн хойт Ази судлал” сэтгүүл, 1996, □1 /7/